

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2021-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2024.11.15

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу Хэлтсийн хэвийн үйл ажиллагааг хангах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор Хэлтсийн даргын 2022 оны А\01 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг баталж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Онцгой байдлын газраар хянуулж баталгаажуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, аймгийн Онцгой байдлын газрын удирдамжийн дагуу жил бүр хэлтсийн ажилчид Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-д эхний дохиогоор ажилчид “Нуугд-Суу-Хүлээ” гэсэн зарчмыг баримтлан өрөө тасалгаандаа өөрийн аюулгүй байдлын хангах, өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч, ширээн доогуур орох, даацын хана, булан тохойд нуугдах арга хэмжээг авч хоёр дахь дохиогоор “Гүйхгүй, Түлхэхгүй, Эргэж буцахгүй, Хашгирахгүй” гэсэн зарчмыг баримтлан аврах гарц ашиглан барилгаас баруун гарын дүрмийг баримтлан гарч “Цугларах талбай”-д гарч бүртгэлд хамрагдаж, хүн нэг бүрийн үүргэвч, иж бүрдэлээ үзүүлж дадлага, сургуульд бүрэн хамрагдаж ажилласан.


Аймгийн Онцгой байдлын газраас мэргэжилтэн урьж Гал унтраах багаж, галын хортой хэрхэн ажиллах талаар байгууллагын ажилчдад мэдээлэл авч, сургалт зохион байгуулсан.

Хэлтсийн даргын 2023 оны А\03 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн байгуулж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хянуулж батлуулсан.

Гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл, хүн нэг бүрийн хувцас, аранз, аранзны иж бүрдэл /эмийн сан, хоол, усны сав/ авахад 1850,0 мянган төгрөг зарцуулж бэлэн байдлыг хангуулж ажилласан.

Аймгийн Онцгой байдлын газраас 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ” сэдэвт сургалтанд тус хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга, иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг хамрагдсан.

ТАЙЛАН БИЧСЭН:
ГЭРЭЭТ АЖИЛТАН  Д.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА  Ц.ТЭГШЖАРГАЛ



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ
БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Биелэлт
1	Байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Хэлтсийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг баталж, мөн хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж аймгийн ОБГ-аар хянуулж батлуулсан.
2	Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг ажилчдынхаа дунд тогтмол зохион байгуулах;	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийн хүрээнд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаар ОБГ-аас мэргэжилтэн урьж ажилчдад сургалт зохион байгуулсан. Аймгийн Онцгой байдлын газраас 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээ" сэдэвт сургалтанд тус хэлтсийн Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг хамрагдсан. 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16.00 цагт Зарлан мэдээллийн дуут дохио 1 дуугарахад хэлтсийн албан хаагчид ширээн доогуур орж аюулгүй байдлаа хангаж, 2 удаа дуугарахад баруун гарын дүрмийг баримтлан объектоос аюулгүйн гарцаар гарч аюулгүйн талбайд нүүн шилжиж ажилласан.
3	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төлөвлөх, зарцуулах;	Хэлтсийн даргын тушаалын дагуу Гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл, хүн нэг бүрийн хувцас, аранз, аранзны иж бүрдэл /эмийн сан, хоол, усны сав/ авахад 1850,0 мянган төгрөг зарцуулж бэлэн байдлыг хангуулж ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:
ГЭРЭЭТ АЖИЛТАН



Д.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ТЭГШЖАРГАЛ



ЗУРГАН ТАЙЛАН

